



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Рояаль олон улсын дээд сургууль

Хөтөлбөрийн нэр: Бизнесийн удирдлага

Индекс: E04130101

Шинжээчийн баг:

Ахлагч: М.Банзрагч

Гишүүд: О.Бурмаа

Н.Батдэлгэр

Он сар өдөр: 2021.01.28

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс:

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БАТС	Бизнесийн Ахисан Түвшний Сургууль
ИЗОУИС	Их Засаг Олон Улсын Их Сургууль
МБТ	Монголын Бүтээмжийн Төв
МЗХ	Монголын Залуучуудын Холбоо
ММХ	Монголын Менежментийн Холбоо
РОДС	Рояаль Олон Улсын Дээд Сургууль
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ХУИС	Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
CLO	Course Learning Outcomes
PEST	Political Economic Scial Technological
PLO	Program Learning Outcomes

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Рояаль олон улсын дээд сургууль Royal international university	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Бизнесийн удирдлага	
Индекс	E04130101	
Шинжээчид	Багийн ахлагч: М.Банзрагч Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал Багийн гишүүн: О.Бурмаа Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Бизнес удирдлагын тэнхимийн профессор Н.Батдэлгэр Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн дэд профессор	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал	
Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/	

Төлөвлөгөө	11/20	Шинжээчийн багийг томилох
	11/23	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	11/23	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг цахимаар хүлээлгэн өгнө.
	12/01	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	01/14	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	12/18, 01/18	Шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийнэ.
	01/28	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	01/28	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	02/01	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	02/01	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны А/118 дугаар тушаал.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Рояль ОУДС эрхэм зорилгоо “Төр нийгмийн бодлогыг тодорхойлох удирдагчдыг бэлтгэх, дэлхийн жишигт нийцсэн боловсролыг түгээн дэлгэрүүлэгч сургалт, судалгаа, консалтингийн олон улсын төв байна” хэмээн тодорхойлсон бөгөөд “Бизнесийн удирдлага” хөтөлбөр төгсөгчдийн эзэмшсэн байх дараах академик мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагыг дараах байдлаар гаргажээ. Үүнд:

Академик мэдлэг: Шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, зарчим, зүй тогтлын цэгцтэй мэдлэгтэй байх; Шинжлэх ухааны үндэслэл, тооцоолол, үнэлгээ, дүгнэлт хийхдээ бодит нотолгоонд үндэслэдэг байх; Монгол эрдэмтдийн дэвшүүлсэн онол үзэл баримтлал, зарчмуудад дүн шинжилгээ хийх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохдоо ашигладаг байх; Тухайн салбарынхаа шинжлэх ухааны чиглэлээр сүүлийн үеийн олон улсын болон монгол эрдэмтдийн дэвшүүлсэн онол үзэл баримтлал, зарчмуудад дүн шинжилгээ хийх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох арга зүй эзэмших; Байгууллагын амжилттай оршин тогтнох, хөгжих үндэс болсон хөгжлийн зорилго, стратеги, төлөвлөгөөний учир шалтгаан, ач холбогдлыг танин мэдэх урдүйтэй байх; Судалгааны арга

зүйд хэрэглэгддэг мэргэжлийн гадаад хэлний мэдлэг эзэмшин мэдээлэл боловсруулан шинжилгээ хийж, хүчин зүйлсийн харилцан хамаарал нөлөөллийг үнэлэх, загварчлах, зүй тогтол, шинэ санаа гаргах, тоон болон чанарын шинжилгээ судалгаа хийх, дүгнэн боловсруулах, боломжит хувилбаруудыг сонгох;

Ур чадвар: Суралцагч тасралтгүй хөгжихийн зэрэгцээ харилцаа, техник, шийдвэр гаргах ур чадвартай байх; Байгууллагын орчин, нөхцөл байдал, төлөвлөгөөний хэрэгжүүлэлтийн явцыг үнэлэх арга загваруудыг өргөнөөр ашиглан мэдээлэл цуглуулдаг байх; Тоон, чанарын, ситуаци нөхцөл байдлын арга хандлага ба бусад бизнесийн судалгаа шинжилгээний арга загваруудыг ашиглан, байгууллагын болон байгууллагын гадаад, дотоод орчны судалгаа хийж, анхдагч болон хоёрдогч мэдээлэл цуглуулах, түүнд боловсруулалт анализ хийх, нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулдаг байх; Судалгааны үр дүнгээс суралцаж, хэрэглээ болгон шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг дэвшүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, цаашдын алхмуудыг тодорхойлох, шинэ хандлагуудыг судалдаг байх;

Харилцаа хандлага: Хууль эрх зүйг дээдлэн мэргэжлийн ёс зүйтэй, судлаачийн хувьд оюуны өмчийн ёс зүйг эрхэмлэсэн хариуцлагатай байх; Хувь хүний нэр төр хувийн нууцад халдахгүй, аливаа мэдээлэл эх үүсвэрийг зүй бусаар ашиглахгүй байх ёс суртахууны төлөвшил эзэмших; Байгууллагад тулгарч буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг судлан, бүтээлчээр сэтгэж, инновац санал боловсруулж өөрийн боловсруулсан саналыг чөлөөтэй илэрхийлэх эрмэлзэлтэй байх; Дэлхийн хэмжээнд сэтгэх, сэтгэл хөдлөлөө удирдах, өөрийгөө удирдах, ажилдаа чин сэтгэлээсээ хариуцлагатай хандах;

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан

- РОУДС-ийн хөтөлбөрийн хорооны 2019 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн хурлын тэмдэглэл
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- Хөтөлбөрийн товч танилцуулга

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- PEST шинжилгээ хийсэн
- ШУТИС, БАТС болон ХААИС, Удирдлагын академийн хөтөлбөрүүдийг харьцуулсан судалсан
- АНУ-ын 2, Английн 1 сургуулийн хөтөлбөрийг судалсан
- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай холбон авч үзсэн байна
- Дэлхий эдийн засгийн формаас гаргасан судалгааны үр дүнг ашиглан хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг томъёолсон байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр нь оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хэрхэн хангасан талаар нотлох баримтаар баталгаажуулах
- Судлаач болон мэргэжлийн магистрын хөтөлбөрийн зааг ялгааг гаргасан хөтөлбөр боловсруулах

Зөвлөмж:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа 38 их, дээд сургууль байна. Эдгээр сургуульд жинд дунджаар хэдэн магистр элсэн суралцдаг талаар судалгаа хийгдээгүй нь, зах зээлийн багтаамж, эрэлтийг тодорхойлоогүй нь хөтөлбөрийг цааш хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үнэхээр байгаа эсэх нь тодорхойгүй
- Магистрын түвшинд бизнесийн удирдлагын хөтөлбөрөөр сургалт эрхэлдэг зөвхөн 4 суруулийн хөтөлбөрийг яагаад харьцуулах болсон шалтгааныг илүү дэлгэрэнгүй оруулж өгөх
- Зөвхөн РОУДС-д элсэн суралцаж буй оюутнуудаас хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох нь өрөөсгөл тул сайжруулах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол улсын БСШУСЯ-ны үйл ажиллагааны эрхэм зорилготой уялдуулан РОУДС-ийн эрхэм зорилго болон Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн зорилгыг нийцүүлэн дахин томъёолсон.
- Хөтөлбөрийн зорилго хэрэгцээ шаардлагад нийцэж байгааг мэдлэг, ур чадвар, хандлага зэргээр задлан хүснэгтээр харуулсан.

Анхаарах асуудал:

- Шинээр томъёолсон сургуулийн эрхэм зорилго, хөтөлбөрийн зорилгыг баталсан нотлох баримт байхгүй.
- Оролцогч талуудын хэрэгцээ шаардлагатай хөтөлбөрийн зорилго хэрхэн нийцэж байгааг баримт, судалгаагаар баталгаажуулах.

Зөвлөмж:

- Тушаал, шийдвэр, хурлын тэмдэглэл зэргээр гаргасан шийдвэрээ баталгаажуулдаг байх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- БШУС-ын “Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” тушаал А/370, 2014.09.12
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- CLO, PLO-г зөвхөн тайлан бичсэн баг л ойлгох нь онцлог байна.

Анхаарах асуудал:

- Тайлан бичиглэлийн хувьд эмх цэгцгүй, уялдаа холбоо байхгүй тул цаашид анхааран сайжруулах.
- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг хэрхэн сайжруулсан талаар тайланд тусгаж нотлох баримтаар баталгаажуулах.
- “... сургалт судалгааг хослуулан судалгаанд суурилсан суралцагч төвтэй сургалтын орчин үеийн дэвшилтэт арга, технологийг ашиглаж байна.” гэдгийг баримтаар баталгаажуулах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн баталгаажуулсан баримт нотолгоогоор хангах, тайланд тусгах.
- Судлаач магистр уу, мэргэжлийн магистр бэлтгэх гэж байна уу гэдгийг тодорхой болгох.

- A/370 тушаалын 2.3 сургалтын төлөвлөгөө хэсэгт заасан 2.3.2 заалтыг мөрдөх .
- Хичээлийн залгамж уялдаа холбоо нарийн зааж өгөх.
- Мэргэжлийн суурь, судалгааны арга зүйн болон мэргэшүүлэх хичээл зэргийг хөтөлбөрт нарийн тусган оруулах.
- CLO, PLO зэргийг дахин томъёолж засварлах.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөлөгөө (2018, 2020 он)
- Хичээлийн хөтөлбөр, багц материалууд
- Хөтөлбөрийн хороо, Эрдмийн зөвлөлийн тэмдэглэл, шийдвэр
- Сургалтын журам

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Гадаад багш нарын уншсан цахим лекцийн хичээлүүд (YouTube платформ)

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтийг тодорхой хугацаа тус бүрээр баталгаажуулж байх шаардлагатай байна.
- Сургалтад оролцогч талуудад магистрын хөтөлбөрийн агуулга тодорхой харагдаж байх шаардлагатай байна. Ингэснээр суралцагч ямар хичээлийг хэзээ судлахаа тодорхой болгох боломжтой болно.
- Өөрийн үнэлгээний тайланд тусгагдсан 2 кредит цагийн багтаамжтай хичээлүүдийн жагсаалт байгаа боловч 2018, 2020 онд тус тус батлагдсан хөтөлбөрт 1 кредит цагийн багтаамжтай хичээлүүд олон тусгагдсан байна. Мөн 2018 оны хөтөлбөрт тусгагдсан зарим хичээл 2020 онд баталсан хөтөлбөрт байхгүй болсон байна Гэхдээ тухайн хичээлүүдийг 2020 онд яагаад хассан талаар хэлэлцсэн агуулга, баримт нотолгоо дутуу байна.
- Магистрын диплом бичиж буй магистрант нь хэдэн удаа хэлэлцүүлэгт оролцож, эцсийн хамгаалалтаас өмнө ямар ажил гүйцэтгэсэн байхыг тодорхой болгох шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Батлагдсан сургалтын журам нь илүү сургалтын үйл ажиллагааны процесст чиглэсэн агуулгатай байна. Сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулгын БШУС-ын сайдын 2014 оны А/370 тоот тушаалтай уялдуулж сайжруулах шаардлагатай байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- X-Cloud платформ
- Цахим хичээлийг YouTube платформд байршуулсан байдал
- Сургалтын журам, дотоод журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төсөл, кейс, асуудал шийдвэрлэх гэх мэт сургалтын идэвхтэй арга зүйг ашигладаг.
- Сургалтын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг мэргэжлийн программаар шинжилдэг.

Анхаарах асуудал:

- Бүх багш нарын цахим хичээлд байршуулсан цахим хичээлийн контентын агуулга ялгаатай байна. (Ялангуяа Монгол багш нарын)

Зөвлөмж:

-

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн сургалтын арга зүй нь багшлахуйн, суралцахуйн арга зүйд суурилсан суралцагч төвтэй дэвшилтэт техник, технологи ашигладаг сайн туршлага байна.
- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжийг олгоход чиглэгдсэн байна.
- Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны мэдлэг, чадварыг үнэлж хэвшсэн, суралцагчдаас судалгаа хийж хэвшсэн байна.
- Багийн ажлыг үнэлэх үнэлгээний рубрик тодорхой.

Анхаарах асуудал:

- Хичээлд суугаагүй суралцагчийг дахин сургалтанд хамруулах шалгуур, шаардлагын талаар журамд тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.

Зөвлөмж:

-

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн онцлогтой холбоотой сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын гадаад болон дотоод орчны талаарх суралцагчдын болон багш нарын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт явуулахад эрүүл, аюулгүй, тохилог орчинг хангасан хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори зэрэг суралцахад таатай дотоод орчныг бүрдүүлж чадсан.
- Сургалтын танхим дахь тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгслийн тоо, ширхэг нь суралцагчдад хүрэлцээтэй.
- Хөтөлбөрөөр суралцагчдад эхлэлийн бизнесийг нь дэмжих зорилготой Start-up бизнес оффисуудтай.

Анхаарах асуудал:

- Сургалтын үйл ажиллагаанд ашигладаг хичээлүүдийн программ хангамжийг шинэчлэн сайжруулж, өнөөгийн нийгэмд зайлшгүй шаардлагатай, мэргэжлийн программ хангамжуудыг нэвтрүүлэх.
- Сургуулийн гадаад орчин талаасаа суралцагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор машины зогсоол, ногоон байгууламжийн асуудлуудад анхаарч ажиллах.

- Сургалтын цахим орчны хэрэгжилтийг нэмэгдүүлэхийн тулд интернэтгүй орчинд нэвтрэх боломжоор хангах .

Зөвлөмж:

- Сургалтын орчныг сайжруулах чиглэлээр хичээлийн жил тутам оролцогч талуудын судалгаанууд хийдэг хэдий ч үр дүнгийн ахиц дэвшил нь төдийлөн харагдахгүй байгаа тул анхаарч ажиллах.
- Хөтөлбөрөөр суралцагчдын судалгааны арга барилыг дээшлүүлэх чиглэлээр лабораторийн хэрэглээг нэмэгдүүлж, орчин үеийн программ хангамжаар хангах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бизнесийн удирдлагын ахисан түвшний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын бүхий л хэрэглэгдэхүүнээр хангагдсан.

Анхаарах асуудал:

- E-Контент түвшний хичээлүүдийг бодлогоор уяж, монгол болон гадаад багш нар ижил платформоор сургалтыг явуулахад анхаарах.
- Сургалтын ажлыг зохион байгуулах удирдамж, зөвлөмжийн талаарх эрх зүйн баримт бичгийг цогцоор нь бүрдүүлж ажиллах.

Зөвлөмж:

- E-Контент түвшний хичээлийн хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр анхаарч, суралцагчдад хүндрэлгүй байдлаар системтэйгээр зохион байгуулах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үндсэн сурах бичиг, номын хэрэгцээний судалгааг жил бүр тогтмол хийж, шаардлагатай гадаад болон дотоодын зохиогчдын ном, сурах бичгийн фондыг баяжуулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутны тооноос хамааралтайгаар мэргэжлийн ном, сурах бичиг, судалгааны бүтээлүүдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах.
- Хөтөлбөрөөр суралцагчдын ном, сурах бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, сүүлийн жилүүдэд туурвигдсан бүтээлүүдээр ном, сурах бичгийн баяжилтыг хийх.

Зөвлөмж:

- Гадаад номын захиалгын тоо болон нэгж номын тоо ширхгийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах.
- Хөтөлбөрөөр суралцагчдын цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэр ашиглах боломжийг нэмэгдүүлж, суралцагчдад түүнийг хэрхэн ашиглах чиглэлийн зөвлөмжүүдийг тогтмол өгдөг байх.
- E-Номын сангийн үйлчилгээг сайжруулах.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан

- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- Хөтөлбөрийн хорооны стратеги төлөвлөгөө 2020-2021
- Төгсөгчдийн мөшгөх судалгааны тайлан

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын сургалтын гарын авлага гарган хүргүүлдэг.
- Morning Glory арга хэмжээний хүрээнд удирдлагууд суралцагчтай өглөө уулзалт зохион байгуулан сургалтын процесс болон тэдний санал бодол, хүсэлтийн талаар нээлттэй ярилцдаг болсон байна.

Анхаарах асуудал:

- www.royalacademy.edu.mn цахим хуудсаар мэдээлэл хүргүүлдэг эсэх нь батлагдаагүй.
- Хөтөлбөрийн дэд, ерөнхий хороо нь хөтөлбөрийг хэрхэн сургалтын чанарыг сайжруулах чиглэлд ямар арга хэмжээ авч ажилдаг эсэхийг баримтаар баталгаажуулах.
- Дүрэм журмын шинэчлэлийг хэрхэн хийж баталгаажуулдаг талаар баримтаар нотлох.

Зөвлөмж:

- Дүрэм журмын баталгаажуулалт тодорхой болгох.
- Оюутнаас ирүүлсэн санал гомдол нь хөтөлбөртэй холбоотой эсэх, тийм бол хөтөлбөрийн чанарыг хэрхэн сайжруулсан талаар тайланд тусгах, нотлох баримтаар баталгаажуулдаг байх
- Дүрэм журмын талаар сургуулийн веб хуудсаар дамжуулан оролцогч талуудад хүргэдэг байх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- Захиалгат сургалтын хөтөлбөр /веб хуудас/

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Их Британийн худалдаа удирдлагын институт, төрийн удирдлагын институт, аялал жуулчлал зочлох үйлчилгээний менежментийн холбоо гэх мэт байгууллагуудтай хамтран ажилладаг, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг зэргээс үзэхэд гадаад харилцааг сайн хөгжүүлж чадсан байна.
- Колорадо олон улсын их сургууль, Виржиниа олон улсын их сургууль, Америкийн үндэсний их сургуулиудтай магистрын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг.
- Дотоодод ММХ, МБТ, ИЗОУИС, МЗХ, ХУИС, ШУТИС-ийн багшийн хөгжлийн төвтэй хамтран ажилладаг.

Анхаарах асуудал:

- Тайланд зөвхөн магистрын хамтарсан хөтөлбөртэй холбоотой мэдээлэл оруулах
- Гадаад болон дотоод хамтын ажиллагааны гэрээ, гэрээний үр дүн, биелэлт зэргийн нотлох баримтаар баталгаажуулах.

Зөвлөмж:

- Контентийн уралдаан оролцож тэргүүн байр эзлэв, бүтээмжийн төвийн зайн сургалтад хамрагдав, ИЗОУИС-аас зохион байгуулсан ЭШ хуралд амжилттай оролцов зэргээр дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээг илэрхийлж байгаа нь учир дутагдалтай байна.
- Дотоодын хамтын ажиллагааны хүрээнд ямар ямар ажлууд хийж гүйцэтгэсэн, төсөл, судалгааны ажилд хэрхэн хамтран оролцсон, оюутнуудыг хэрхэн татан оролцуулсан зэргийн илүү дэлгэрэнгүй тайланд оруулах, нотлох баримтаар баталгаажуулах шаардлагатай

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- Багш ажилчдын хөгжлийг дэмжих журам

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нэг магистрантад ногдох зардлын тооцоог гаргасан.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг зардлын хувь хэмжээг сүүлийн 3 жилээр гаргасан.
- Тэтгэлэг олгосон байдал сүүлийн 3 жилээр.
- Багш нарт олгосон урамшуулал, санхүүгийн дэмжлэг болон мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой зардал, сүүлийн 3 жилээр тус тус гаргасан байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын орлогоос судалгааны зардалд зарцуулах хувь хэмжээ 5% байгааг нэмэгдүүлэх.
- Багш нарын магистрантурт суралцах зардлын тодорхой хувийг сургуулиас гаргасан боловч докторантурт суралцах багшийн сургалтын зардлын тодорхой хувьд сургуулийн зүгээс дэмжлэг үзүүлдэг байх, журмаар баталгаажуулах.
- Гадаад болон хамтын ажиллагааны хүрээнд сургалтын бус орлого оруулдаггүй, хамтарсан төсөл гэрээт ажил судалгаа хийдэггүй буюу санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрдүүлж чадаагүй.

Зөвлөмж:

- Хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөр, судалгааны гэрээт ажлын тоог нэмэгдүүлэх, орлогын олон талт эх үүсвэрийг бий болгох.
- Оюутны мэргэжлийн болон хувь хүний хөгжилд зарцуулсан нийт төсвийн 9%-ийн задаргааг гарган баримтаар баталгаажуулах.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- Байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээ

Шалгуурыг хангасан байдал: Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- байхгүй

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- Сургуулийн веб хуудас

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан Онцлог зүйл/Туршлага:

- Бакалавр, магистрын болон захиалгат сургалтын мэдээллийг сургуулийн веб хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэдэг.
- Магистрын хөтөлбөрийн давуу тал, ач холбогдол зэргийг Рояал, Малчин, Монгол ТВ, UBS, TV-5 зэрэг телевизүүд болон өдөр тутмын хэвлэлээр дамжуулан хүргэдэг.

Анхаарах асуудал:

- Телевизтэй хийсэн өмнөх гэрээний биелэлтийг баталгаажуулах.
- Магистрын хөтөлбөрийн давуу тал, ач холбогдол зэргийг Рояал, Малчин, Монгол ТВ, UBS, TV-5 зэрэг телевизүүд болон өдөр тутмын хэвлэлээр дамжуулан хүргэдэг гэдгийг нотлох баримтаар баталгаажуулах.
- Ажлын байрны зар, шар сэтгүүлийн мэдээ зэрэг нь хөтөлбөртэй холбоотой хэсгийг л нотлох баримтаар баталгаажуулах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Богино хугацаанд мэдээлэл хүргэх боломжтой олон нийтийн сүлжээг ашигладаг байх, хэрвээ ашигладаг бол тайланд тусгах.
- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэдэх эсэхийг баримтаар баталгаажуулах, судалгаагаар баталгаажуулах.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэлтийн болон шилжих хөдөлгөөний тушаал, шийдвэр
- Элсэгчдийн хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинэ элсэгчдэд зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн элсэлтийн журамтай ба түүнийг шинэчлэн сайжруулдаг
- Шинэ элсэгчдэд зориулсан гарын авлагатай, жил бүр тогтмол шинэчилдэг
- Шинэ элсэгчдийг хүлээн авах ёслолтой ба олон төрлийн хэлбэрээр /уулзалт, спорт өдөрлөг, урлагийн гэх мэт/ зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгын онцлогтой уялдуулан элсэгчдэд тавигдах шаардлагаа шинэчлэн сайжруулах
- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах

Зөвлөмж:

- Элсэгчдийн хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааг жил бүр хийдэг хэдий ч судалгааны үр дүнд ямар асуудлуудыг бодлогоор дэмжиж сайжруулсан болон хэрхэн өөрчлөлт оруулсан талаарх дүгнэлтүүдийг өгдөггүй байдалд анхаарах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдад чиглэсэн урлаг, спортын болон олон нийтийн 10 гаруй үйл ажиллагаа нь тогтмолжсон.

Анхаарах асуудал:

- Ахисан түвшний хөтөлбөр хэрэгжүүлж буй тул суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны арга барилыг хөгжүүлэх чиглэлд анхаарах.
- Суралцагчдаас сургуулийн бүтэц, нэгжийн үйлчилгээ, хүртээмж, харилцааны талаарх судалгааг цогцоор нь авч, үр дүнг хэмжих.
- Суралцагчдыг төсөлт ажил, судалгааны ажил, судлаачдын хамтарсан бүтээлүүдэд судлаачаар хамруулахад хөтөлбөрийн зүгээс бодлогоор хангаж, зөвлөн туслах.

Зөвлөмж:

- Суралцагчдыг эрдэмжүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааг нэгж бүр тус тусдаа бус, орхигдуулсан нэгжүүдийг хамруулан цогц судалгааг хийх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил болон үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчдын тоо, үр дүнгийн мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрт суурилсан мэргэжлийн хэд хэдэн клуб үйл ажиллагаагаа явуулдаг.

Анхаарах асуудал:

- “Суралцагчдад урамшуулал олгох журам” байгаа хэдий ч түүнийг хэрхэн зохион байгуулж буй хэрэгжилт нь тодорхойгүй
- Сургуулийн хамтын ажиллагааны олон гэрээнүүд хийгдсэн боловч ахисан түвшний суралцагчдыг хэрхэн цагийн болон үндсэн ажилд зуучилж өгөх бодлогын асуудлууд тусгагдаагүй, зуучилж өгсөн суралцагчдын тоо бага, нотлох баримтгүй

Зөвлөмж:

- Суралцагч болон төгсөгчдийг цагийн болон үндсэн ажилд зуучилж өгөхөд анхаарах.
- Мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээнд суралцагчдыг идэвхжүүлэн дэмжиж, үр дүн гаргасан суралцагчдад урамшууллыг олгоход анхаарах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн багц цагийн дүйцэл, шилжих хөдөлгөөний асуудлыг зохицуулах эрх зүйн заалттай.
- Суралцагчийн шилжих хөдөлгөөний судалгааг жил бүр хийдэг.

Анхаарах асуудал:

- Суралцагчдыг сургуулиас гарах, жилийн чөлөө авах, эсвэл шилжин суралцах байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор санал, өргөдлийн системдээ тулгуурлан ирээдүйн шилжих хөдөлгөөний асуудлыг төлөвлөдөг байх

Зөвлөмж:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгааны үр дүнд бодлогын хувьд үйл ажиллагаагаар дэмжин гүйцэтгэж, ахиц дэвшлийг үнэлдэг байх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар болон төгсөлтийн баримт бичгийг олгох журмын хэрэгжилт нь Дээд боловсролын тухай хууль, БСШУСЯ-наас баталсан нийтлэг загвар стандартад бүрэн нийцсэн байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- РОУДС-ийн багш нарын ажлын үр дүнг харгалзан олгон цалингийн журам
- РОУДС-ийн багшийн албан тушаалын зэрэглэл олгох журам
- Багш нартай хийсэн гэрээ
- Рояль олон улсын дээд сургууийн багшийн ажлын үнэлгээний журам (удирдах зөвлөлийн 2017.10.20-ны тогтоолын хавсралт)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд докторын зэрэгтэй үндсэн багшийн тоо өссөн байна. (2015 оны 4 багш – 2019 онд 6 багш)
- Багш нарыг магистрантурт суралцахад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлж байна.

Анхаарах асуудал:

- Шинэ багш сонгон шалгаруулалтанд Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багийн оролцоо бага байна.
- Үндсэн багш, цагийн багшийн харьцааг анхаарах шаардлагатай байна (ӨҮТ-нд Үндсэн багш 6, цагийн багш 16).
- Үндсэн багшийн ажлын цагийн үнэлгээ, цагийн багшийнхаас бага байгааг анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Магистрын хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд, залуу багш нарыг докторантурт суралцах, хамгаалахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш, ажилтныг гадаад улсад суралцах, хурал зөвлөгөөнд оролцоход нь дэмжлэг үзүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Багш нарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн ажлыг төлөвлөх шаардлагатай.

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр, карьерийн төлөвлөгөөг тодорхой болгох шаардлагатай.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын бүтээлийн жагсаалт
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар цөөнгүй тооны магистрант удирдаж хамгаалуулдаг.

Анхаарах асуудал:

- Багш нарын бүтээлийн жагсаалтаас харахад, багш нарын бичиж хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил цөөн байгаад анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Судалгааны ажил бичиж төгсөж буй магистрантуудтайгаа хамтарсан ЭШ-ний хурлын илтгэл, сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Зөвхөн судалгааны ажил бичиж төгсөж буй магиструудын хувьд, эрдэм шинжилгээний ажлыг ЭШХ-д хэлэлцүүлэх, өгүүлэл хэвлүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- РОУИС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл
- Хөтөлбөрийн товч танилцуулга

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

•

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээнээс ялгаатай болохыг анхаарах.
- Оролцогч талуудын оролцоотойгоор хөтөлбөрийг хэрхэн сайжруулсан эсэхийг нотлох баримтаар баталгаажуулах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн дэд болон ерөнхий хороо байгуулсан тушаал, гаргасан шийдвэрийг зэргийг нотлох баримтаар баталгаажуулах.
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл 1 байгаа нь хэзээ хуралдсан эсэх нь тодорхой биш байгаа тул анхаарах, хавтас, файл бүрдүүлэх.
- Архив, албан бичиг баримт хөтлөлтийг сайжруулах.
- Хөндлөнгийн үнэлгээг хэрхэн хийлгэдэг талаар баталгаажуулсан механизмтай болох .

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх өөрийн үнэлгээний тайлан
- Тайлан бичсэн багийн гишүүнтэй хийсэн ярилцлага
- Мөшгөх судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мөшгөх судалгааг жил бүр хийн судалгааны тайлан хэвлүүлдэг

Анхаарах асуудал:

- Судалгааны үр дүнд хөтөлбөрийг хэрхэн сайжруулсан талаар тайланд тусгах, нотлох баримтаар баталгаажуулах.

Зөвлөмж:

- Судалгааны асуулга нь ШУ-ны ач холбогдолтой эсэхэд анхаарах.
- Сонирхогч болон оролцогч талуудын хэрэгцээ шаардлага нийлүүлэн хөтөлбөрийг хэрхэн шинэчилсэн эсэхийг баримтаар баталгаажуулах.
- Өмнөх болон сайжруулсан хөтөлбөрийн ялгаа нь сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангасан, бодитой өөрчлөлт болж чаддаг эсэхэд анхаарах. Хөтөлбөрийн үр дүн, шинэчлэл нь сонирхогч талуудын сэтгэл ханамжид бодит нөлөөлсөн эсэхийг динамикаар харуулах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ВАС-аар магадлан итгэмжлэгдсэн (байгууллага)
- Европын Бизнесийн Ассамблейн олон улсын шилдэг байгууллага
- IAO олон улсын байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн
- IAM, ICM, CTN олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгч
- Хамтарсан хөтөлбөрүүд хамрагдах бүрэн боломжтой
- Гадаад профессор, багш нарын тоо харьцангуй их
-

Анхаарах асуудал:

- Архив, албан бичиг баримт хөтлөлтийг сайжруулах.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үнэлгээ, БСШУЯ-ны аттестатчилал, байгууллагын үнэлгээ зэргийг тайланд ялган тусгах.

Зөвлөмж:

- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлээр баталгаажуулах. Тухайлбал, ACBSP гэх мэт.
- Сургалтын амжилтыг Peregrine гэх мэт олон улсын байгууллагаар үнэлүүлэх.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөр

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт		2	1	Хэсэгчлэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	2	1		Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин нөхцөл	2	1		Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт		4	1	Хэсэгчлэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	4	1		Бүрэн хангасан
6	Багшлах бүрэлдэхүүн	2	1		Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	1	2		Хэсэгчлэн хангасан
Дүгнэлт		Хэсэгчлэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Рояль олон улсын дээд сургуулийн “Бизнесийн удирдлага” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнесийн удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: М.Банзрагч

Шинжээчийн багийн гишүүн: О.Бурмаа

Шинжээчийн багийн гишүүн: Н.Батдэлгэр

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Рояль олон улсын дээд сургууль
Хөтөлбөрийн нэр	Бизнесийн удирдлага
Хөтөлбөрийн индекс	E04130101
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Батлагдсан сургалтын журам нь сургалтын үйл ажиллагааны процесст илүү чиглэсэн агуулгатай байна. Тус журмыг сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулгын талаар агуулгыг нэмж БШУС-ын сайдын 2014 оны А/370 тоот тушаалтай уялдуулж сайжруулах.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрөөр суралцагчдын судалгааны арга барилыг дээшлүүлэх чиглэлээр лабораторийн хэрэглээг нэмэгдүүлж, орчин үеийн программ хангамжаар хангах. Е-Контент түвшний хичээлийн хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр анхаарч, суралцагчдад хүндрэлгүй байдлаар системтэйгээр зохион байгуулах. Хөтөлбөрөөр суралцагчдын цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэр ашиглах боломжийг нэмэгдүүлж, суралцагчдад түүнийг хэрхэн ашиглах чиглэлийн зөвлөмжүүдийг тогтмол өгдөг байх.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Суралцагчдыг эрдэмжүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх. Мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээнд суралцагчдыг идэвхжүүлэн дэмжиж, үр дүн гаргасан суралцагчдад урамшууллыг олгоход анхаарах. Суралцагч болон төгсөгчдийг цагийн болон үндсэн ажилд зуучлахад анхаарах.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Магистрын хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд, залуу багш нарыг докторантурт суралцах, эрдмийн зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлэх. Багш нарын эрдмийн ажлыг дэмжиж, сүүлийн үед бичиж хэвлүүлсэн өгүүлэл, ЭШ-ний ажилд анхаарал хандуулах.
ШААРДЛАГА	
Хэсэгчлэн хангасан юм уу хангаагүй гэсэн дүгнэлт өгсөн шалгуур, дэд шаардлага бүрд заавал шаардлага бичнэ.	
Шалгуур 1 Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн зах зээлийн багтаамж, эрэлт хэрэгцээг өргөн хүрээнд тодорхойлж, сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг үндэслэлтэй гаргах, нотлох баримтаар баталгаажуулах.

	<ul style="list-style-type: none"> • А/370 тушаалын 2.3 буюу сургалтын төлөвлөгөө хэсэгт заасан 2.3.2 заалтыг мөрдөх; Судлаач магиструу мэргэжлийн магистр бэлтгэх гэж байна уу гэдгийг тодорхой болгох. • Хичээлийн залгамж уялдаа холбоо нарийн тодорхойлж, мэргэжлийн суурь, судалгааны арга зүйн болон мэргэшүүлэх хичээл зэргийг хөтөлбөрт нарийн тусган оруулж, CLO, PLO-г дахин томъёолж засварлах. • Хөтөлбөрийг хэлэлцэж баталгаажуулдаг нэгжийг тодорхой болгох, тушаал, шийдвэр, хурлын тэмдэглэл зэргээр гаргасан шийдвэрээ баталгаажуулдаг байх.
Шалгуур 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл	<ul style="list-style-type: none"> • Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн өөрчлөлтийг тухай бүрд нь баталгаажуулж, баталгаажуулсан баримт нотолгоог бүрдүүлдэг байх.
Шалгуур 3.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> • Гадаад номын захиалгын тоо болон нэгж номын тоо ширхгийг нэмэгдүүлэх. • Е-Номын сангийн үйлчилгээг сайжруулах.
Шалгуур 4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөр, судалгааны гэрээт ажлын тоог нэмэгдүүлэх, орлогын олон талт эх үүсвэрийг бий болгох. • Хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох. • Хөтөлбөрийн удирдлага нь сургалтын чанар, хөтөлбөрийн шинэчлэлийг хийдэг, тогтмол хяналт тавьж ажиллах. • Оролцогч болон сонирхогч талуудын оролцоотой сургалт, хөтөлбөрийг сайжруулах механизмтай болох. • Профессор, багш нарын төсөл гэрээт ажлыг тоог нэмэгдүүлэх, судлаач оюутнуудыг хамтарсан судалгаанд оруулдаг байх, судалгааны хамтын ажиллагааг өргөжүүлэх. • Архив, албан бичиг хөтөлбөрийг сайжруулах, залгамж халааг бий болгох.
Шалгуур 5.2 Зөвлөн туслах үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Ахисан түвшний хөтөлбөр хэрэгжүүлж буй тул суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны арга барилыг хөгжүүлэх чиглэлд анхаарах. • Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааг нэгж бүр тус тусдаа бус, орхигдуулсан нэгжүүдийг хамруулан цогц судалгааг хийж, үр дүнг үйл ажиллагаа болгон хувиргах.
Шалгуур 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн жил тус бүрд үндсэн багш нарын бичиж хэвлүүлсэн өгүүлэл, ЭШ-ний ажлын тоо цөөн байгаа тул магистрантуудтай хамтарсан өгүүлэл бичиж хэвлүүлэх талаар анхаарах.

<p>Шалгуур 7 Чанарын үнэлгээ, баталгаажуулалт</p>	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмтай болох; Сэтгэл ханамжийн судалгааны асуулгаа боловсронгуй болгох, хөтөлбөрийн чанарт чиглүүлэх. Өмнөх болон сайжруулсан хөтөлбөрийн ялгаа нь сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангасан, бодитой өөрчлөлт болж чадсан эсэхэд дүн шинжилгээ хийх. Хөтөлбөрийн ерөнхий, дэд хороо байгуулагдсан бичиг баримт, Бизнесийн удирдлага хөтөлбөрийг хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл зэргийг нотлох баримтаар бүрдүүлэх, архив, албан бичиг хөтлөлтийг сайжруулах, залгамж халааг бий болгох. Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг хийх.
---	--

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Дашдорж Болдбаатар	Эрдмийн зөвлөлийн дарга	Доктор	40	Удирдлагын шийдвэр гаргалт, Санхүүгийн тайлангын шинжилгээ
2	Дамдинрагчаа Төмөрчөдөр	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Доктор	39	Санхүүгийн удирдлага, Удирдлагын нягтлан бодох бүртгэл
3	Дагвасамбуу Чинцэцэг	Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн удирдагч	Доктор	34	Удирдлагын эдийн засаг, Стратегийн менежмент
4	Giuseppe Sapienza	Эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал	Доктор	2	Судалгааны арга зүй, Инновацийн удирдлага
5	Young Rae Kim	Бизнесийн багш	Доктор	6	Бизнесийн статистик, Хүний нөөц
6	Чимэддамба Эрдэнэчулуун	Бизнесийн багш	Доктор	30	Удирдлагын сэтгэл зүй
7	Тунсаг Ганхүү	Бизнесийн багш	Доктор	15	Хэрэглэгчийн харилцаа , Хүний нөөц
8	Аюуш Сүнжидмаа	Цагийн багш	Доктор	22	Удирдлагын сэтгэл зүй
9	Очирбат Сийлэгмаа	Цагийн багш	Доктор	22	Судалгааны арга зүй

10	Ядамдорж Эрдэнэчимэг	Үндсэн багш	Доктор	21	Хүний нөөц, маркетингийн удирдлага
11	Балган Батбаяр	Цагийн багш	Доктор	18	Төслийн менежмент, Инновацийн удирдлага

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Дашдаваа Давааням	701	Оюутны сайн дурын байгууллага
2	Батбаяр Ариунтуяа	701	Голч 3.2
3	Далайхүү Нандинцэцэг	701	ЭШСудалгааны ажил
4	Баянхүү Долгион	703	Голч 3.4
5	Мөнхбат Энхбат	701	Спорт /Чөлөөт бөх -спортын мастер/
6	Баярсайхан Оюун-Эрдэнэ	701	Голч 3.2
7	Ганданбалжир Мөнх-Эрдэнэ	701	магистрант
8	Инжинааш Лхагвасүрэн	601	Нийгэмд эзлэх байр суурь
9	Волож Одхүү	601	магистрант
10	Мөнхцэнгэл Тэмүүлэн	701	Оюутны сайн дурын байгууллага
11	Өлзийбуян Батзаяа	701	Спорт / волейбол /
12	Эрхэмбаяр Ганчимэг	701	Нийгэмд эзлэх байр суурь

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Цэгмид Дамчаа	ИЗОУИС	Их Засаг Цогцолборын захирал
2	Оюунбаатар Бямбабаатар	GEM group	Үйлчилгээний албаны дарга
3	Төмөр-Очир Дөлгөөн	Моннис групп	Хүний нөөцийн мэргэжилтэн
4	Пүрэвийн Түвшин	Эн би жи монголиа ХХК	Захирал
5	Мангалжав Ариунболд	Мастихин ХХК	Захирал
6	Маньбазар Говьсайхан	Хүрэл Ордон ХХК	Захирал
7	Дашдорж Баярсайхан	Air Busan - Airline МДТГ	Захирал
8	Цэлээ Алтангэрэл	Хүннү хөдөө арал жуулчны бааз	Дарга
9	Оюунгэрэл Мөнхдалай	Тамгат тайж ХХК	Захирал
10	Хүрэлбаатар Төгсбилэг	BST property service ХХК	Гүйцэтгэх захирал
11	Отгонбаяр Мөнхсайхан	Багануур ХХК	Мэдээлэл технологийн албаны дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
---	-----------	------------	-------------	--------------

1	Эрдэнэцогт Содцэцэг	2018	РОУИС	Гадаад харилцааны мэргэжилтэн
2	Ганзориг Уранчимэг	2018	ИЗОУИС	Сургалтын албаны мэргэжилтэн
3	Хашбаатар Дөлгөөн	2018	МИАТ	Онгоцны ахлах үйлчлэгч
4	Пүрэвдорж Алтаннавч	2018	REMAX	Борлуулалтын менежер
5	Эрдэнэцэцэг Ганчимэг	2018	EMART	Чанарын албаны дарга
6	Бат-Ирээдүй Батжаргал	2017	ИЗОУИС	ЧСОУС-ийн декан
7	Баяртогтох Төмөрбаатар	2018	Үйзэн тайж ХХК	Ерөнхий захирал
8	Дондовравдан Отгонзаяа	2018	Han Mon Law LLC	Санхүүгийн албаны дарга
9	Загдсүрэн Мөнгөнболор	2020	РОУИС	Архитектурын хөтөлбөрийн удирдагч
10	Раднаабазар Ганчимэг	2020	Интернет худалдаа	Менежер
11	Эрдэнэбаатар Орхон	2020	ШУТИС-ын дэргэдэх УУХүрээлэн	Эрдэм шинжилгээний ажилтан
12	Отгонсүрэн Мөнхзул	2020	Монгол Экспресс ХХК	Тээврийн менежер

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



**РОЯАЛЬ ОЛОН УЛСЫН
ИХ СУРГУУЛЬ**

13381 ш/х-349, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их тойруу, 11-р хороо
Утас: 7711-6633
факс: (976) 7015-5736
E-mail: info@royalacademy.edu.mn,
Вэб сайт: www.royalacademy.edu.mn

2021.02.08 № 103
таний _____-ны № _____-т

Хүсэлт хүргүүлэх тухай:

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН

ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ-Д

Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс ирсэн шинжээчийн тайланд тусгагдсан шаардлага, анхаарах асуудлын дагуу дараах тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Шалгуур нэг хөтөлбөр төлөвлөлт, шалгуур дөрөв хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, шалгуур долоо чанарын үнэлгээ баталгаажуулалт мөн шалгуур хоёрын 2.1-т тусгагдсан анхаарах асуудалд тайлбарыг оруулан болно.

Хавсралтаар хүргүүлсэн тайлбарыг хүлээн авна уу.

Та бүхний ажилд амжилт хүсье!

СУРГАЛТ, ГАДААД ХАРИУЦЛАА
ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ



Б.ДОЛГӨӨН

Шинжээчийн тайлангийн шаардлагад өгсөн тайлбар			
№	Шалгуур	Шаардлага	Тайлбар
1	Шалгуур 1 Хөтөлбөрийн төлөвлөлт	Хөтөлбөрийн зах зээлийн багтаамж, эрэлт хэрэгцээг өргөн хүрээнд тодорхойлж, сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг үндэслэлтэй гаргах, нотлох баримтаар баталгаажуулах.	Нийт 85 их дээд сургуулиудад 148.256 суралцагчидын 30 хувь нь БУ-ын чиглэлээр суралцаж байна. Үүнээс Улсын сургуульд 60 хувь, хувийн сургуульд 40 хувь нь суралцаж байна. РОУИСургуулийн хөтөлбөрт элсэн суралцах суралцагч нь нийт зах зээлийн 15.3 хувь гэж үзэж байна. Үүнийг шалгуур 1-нотлох баримтны бенчмаркийн судалгаанд тусгагдсан.
2	Шалгуур 1 Хөтөлбөрийн төлөвлөлт	Хөтөлбөрийг хэлэлцэж баталгаажуулдаг нэгжийг тодорхой болгох, тушаал, шийдвэр, хурлын тэмдэглэл зэргээр гаргасан шийдвэрээ баталгаажуулдаг байх.	Хөтөлбөрийн хороо байгуулсан гишүүд томилсон тушаалтай. Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлтэй.
3	Шалгуур 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл	Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн өөрчлөлтийг тухай бүрд нь баталгаажуулж, баталгаажуулсан баримт нотолгоог бүрдүүлдэг байх.	Эрдмийн зөвлөл болон хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл байгаа. Өмнөх жилүүдийн баталгаажсан сургалтын төлөвлөгөө хадгалагдан үлддэг.
4	Шалгуур 4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох. Хөтөлбөрийн удирдлага нь сургалтын чанар, хөтөлбөрийн шинэчлэлийг хийдэг, тогтмол хяналт тавьж ажиллах.	Хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх маркетингийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөөтэй. Шалгуурын нотлох баримтанд орсон. Сургалтын чанар, хөтөлбөрийн шинэчлэлийг хөтөлбөрийн хорооны хурал хийдэг. Хөтөлбөрийн удирдлага нь багш нарын хичээлд сууж, хяналт тавин ажилладаг. Багш нарын хичээлийн бэлтгэл ажлыг шалгах үүрэгтэй.
	Шалгуур 7 Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмтай болох; Хөтөлбөрийн ерөнхий, дэд хороо байгуулагдсан бичиг баримт, Бизнесийн удирдлага хөтөлбөрийг хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл зэргийг нотлох баримтаар бүрдүүлэх, архив, албан бичиг хөтөлбөрийг сайжруулах, залгамж халааг бий болгох.	Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмтай бөгөөд хүснэгтлэн тайлан оруулсан. Хөтөлбөрийн хороо байгуулсан тушаал,хөтөлбөрийг хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл байгаа.
Шинжээчийн тайлангийн анхаарах асуудалд өгсөн тайлбар			
№	Шалгуур	Анхаарах асуудал	Тайлбар
1	2.1	Сургалтад оролцогч талуудад магистрын хөтөлбөрийн агуулга тодорхой харагдаж байх шаардлагатай байна. Ингэснээр суралцагч ямар хичээлийг хэзээ судлахаа тодорхой болгох боломжтой болно.	Сургалтын төлөвлөгөө болон мэдлэг, хандлага, үр чадвар нь сургуулийн цахим хуудсанд байрласан. Тухайн магистрантын улирал болон судлах хичээлийн жагсаалт, хэдэн кредит судлах нь тодорхой тусгагдан сургалтын график төлөвлөгөөг гарган, захирлаар баталгаажуулан оюутны мэдээллийн самбар дээр байрлуулсан. Оюутны гарын авлагаар хүргүүлсэн. Шалгуур 2-ийн нотлох баримтанд хавсрагдсан.
2	2.1	Магистрын диплом бичиж буй магистрант нь хэдэн удаа хэлэлцүүлэгт оролцож, эцсийн хамгаалалтаас өмнө ямар ажил гүйцэтгэсэн байхыг тодорхой болгох шаардлагатай байна.	Сургалтын график төлөвлөгөөг тодорхой гаргасан бөгөөд хэдэн удаа хэлэлцүүлэгт оролцож, эцсийн хамгаалалтаас өмнө ямар ажил гүйцэтгэсэн байхыг суралцагчийн гарын авлага болон магистрын сургалтын журамд хавсралтаар орсон. Суралцагчийн үнэлгээнд магистрын судалгааны ажлын явцыг хэрхэн үнэлэх нь тусгагдсан.
3	4.3	Гадаад болон хамтын ажиллагааны хүрээнд сургалтын бус орлого оруулдаггүй, хамтарсан төсөл гэрээт ажил судалгаа хийдэггүй буюу санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрдүүлж чадаагүй.	Бизнесийн удирдлагын магистраар төгссөн оюутнууддаа богино хэмжээний төлбөртэй сургалтууд зохион байгуулдаг бөгөөд бусад ААНБ-аас захиалгат сургалт / төлбөртэй/ авдаг.

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/